



Хан-Уул дүүргийн Статистикийн хэлтэс

# ХАН-УУЛ ДҮҮРГИЙН АВТОМАШИНЫ ТОО



УЛААНБААТАР ХОТ  
2018 ОН



2017 оны техникийн хяналтын улсын үзлэгт Хан-Уул дүүргийн 37.9 мянган тээврийн хэрэгсэл хамрагдаж, өнгөрсөн оныхоос 3510 тээврийн хэрэгслээр нэмэгджээ.

Хан-Уул дүүрэгт бүртгэлтэй автомашины тоо сүүлийн 3 жилд дунджаар 12.1 хувиар өсчээ. Тухайлбал, 2015 онд 19.6 хувиар, 2016 онд 6.5 хувиар, 2017 онд 10.2 хувиар өмнөх оныхоос тус тус өссөн байна.

Нийслэлийн хэмжээнд техникийн хяналтын үзлэгт хамрагдсан нийт тээврийн хэрэгслийн 10.4 хувийг Хан-Уул дүүрэгт бүртгэлтэй тээврийн хэрэгсэл эзэлж байна.

Хүснэгт 1. Автомашины тоо, төрлөөр, 2015-2017 он

	2015	2016	2017	Автомашины тоо, төрлөөр				Амины автомашин	
				Суудлын	Ачааны	Автобус	Тусгай	2016	2017
Нийслэлийн дүн	331564	339626	365819	282182	67699	9924	6014	275084	294472
Хан-Уул дүүрэг	32344	34444	37954	29367	6386	1370	831	27316	29077

2017 онд дүүргийн техникийн хяналтын үзлэгт хамрагдсан нийт 37954 тээврийн хэрэгслийн 77.4 хувийг суудлын автомашин эзэлж байгаа бол 16.8 хувь нь ачааны, 3.6 хувь нь автобус, 2.2 хувь нь тусгай зориулалтын автомашин тус тус эзэлж байна.

Хүснэгт 2. Автомашины тоо, ашиглалтын хугацаагаар

	2016				2017			
	Бүгд	0-3 жил	4-9 жил	10-аас дээш	Бүгд	0-3 жил	4-9 жил	10-аас дээш
Нийслэлийн дүн	339626	9104	74891	255631	365819	8706	82861	274252
Хан-Уул дүүрэг	34444	2336	8986	23122	37954	2746	10025	25183

2017 оны техникийн хяналтын үзлэгт хамрагдсан дүүргийн нийт тээврийн хэрэгслийн ихэнх буюу 66.4 хувийг арав ба түүнээс дээш жилээр ашиглаж, хуучирсан тээврийн хэрэгслүүд эзэлж байна. Улаанбаатар хотод техникийн хяналтын үзлэгт хамрагдсан нийт тээврийн хэрэгслийн 274.2 мянган (75.0 %) тээврийн хэрэгсэл нь арав ба түүнээс дээш жилээр ашиглаж, хуучирсан тээврийн хэрэгслүүд байна. Үйлдвэрлэгдэж гарсан хугацаанаас хойш 0-3 жил ашиглаж буй шинэ автомашины тоо дүүргийн хэмжээнд нийт тээврийн хэрэгслийн 7.2 хувийг эзэлж байгаа нь өмнөх оныхоос 0.4 пунктээр өссөн дүнтэй байна.

Хүснэгт 3. Тээврийн салбарын үндсэн үзүүлэлт

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016	2017
Нийт орлого	сая.төг	1284.9	917.4
Зорчигчдын тоо	мян.хүн	1840.3	1528.3
Зорчигч эргэлт	мян.хүн.км	6257.0	5196.2

Дүүргийн нийтийн тээврийн үйлчилгээний аж ахуйн нэгжүүд 2017 онд 5196.2 мянган хүн километрийн ажил үйлчилгээг гүйцэтгэн, давхардсан тоогоор нийтдээ 1528.3 мянган хүн тээвэрлэж, 917.4 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Зорчигчдын тоо өмнөх оныхоос 312.0 мянган хүнээр (17.0 %) буурч, үйлчилгээний орлого 367.5 сая төгрөгөөр (28.6%) буурчээ. Тээврийн салбарын үндсэн үзүүлэлт, үйлчилгээний орлогын бууралтад зорчигч тээврийн үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгж байгууллагын автобусны тоо буурсан нь нөлөөлжээ.

Хүснэгт 4. Автобусны буудлын тоо

Дүүрэг	2016			2017			Стандартын шаардлага хангасан талбайтай зогсоол	Зогсоолын тэмдэгтэй
	Бүгд	Үүнээс:		Бүгд	Үүнээс:			
		Эцсийн зогсоол	Дундын зогсоол		Эцсийн зогсоол	Дундын зогсоол		
Хан-Уул	59	9	50	187	9	178	43	143

Нийтийн тээврийн үйлчилгээний автобусны дундын болон эцсийн зогсоолын байршлыг тогтоох, нэгдсэн мэдээллийн сан үүсгэх, тогтоосон байршлыг баталгаажуулах асуудлыг холбогдох мэргэжлийн байгууллагууд хамтарч шийдвэрлэх зорилгоор хийгдсэн үзлэгээр Хан-Уул дүүргийн хэмжээнд 2017 онд нийтдээ 187 автобусны буудал, зогсоол байгааг тогтоожээ. Нийт буудал, зогсоолын 4.8 хувийг эцсийн, 95.2 хувийг дундын зогсоол эзэлж байгаа бөгөөд 23.0 хувь нь стандартын шаардлага хангасан, 76.5 хувь нь автобусны зогсоолын тэмдэгтэй байжээ. Автобусны буудлын тоог өмнөх онтой харьцуулбал 3.1 дахин нэмэгдсэн байна.

Танилцуулга бичсэн: Статистикийн хэлтсийн мэргэжилтэн Д.Оюунгэрэл